

Төсөл
Хууль зүй, дотоод хэргийн сайд, Боловсрол,
соёл, шинжлэх ухаан, спортын сайдын хамтарсан
2018 оны дугаар сарын-ны өдрийн /.....
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

**ХУВИЙН ХАМГААЛАЛТЫГ БИЕЧЛЭН ГҮЙЦЭТГЭХ БОЛОВСОН ХҮЧНИЙГ БЭЛТГЭХ,
ДАВТАН СУРГАХ, МЭРГЭЖЛИЙГ НЬ ДЭЭШЛҮҮЛЭХ СУРГАЛТЫН АГУУЛГА, ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Сургалтын чиглэл, сэдэв	Агуулга	Бүгд цаг	Лекц	Дадлага	Сургалтад хамрагдаж буй иргэнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар
Нэг: Хувийн хамгаалалтыг биечлэн гүйцэтгэх алба хаагчийг бэлтгэх анхан шатны сургалт						
1	Хувийн хамгаалалтын алба хаагчийн эрх зүйн байдал	<ul style="list-style-type: none"> • Харуул хамгаалалтын тухай ойлголт, хувийн харуул хамгаалалтын үйл ажиллагааны онцлог • Хувийн нууцын тухай хуулийн ойлголт, зохицуулах зүйл, зохицуулалтын арга • Хувийн хамгаалалтын тухай хуулийн зохицуулалт, үйлчлүүлэгчтэй байгуулах гэрээ, талуудын хүлээх, үүрэг, хариуцлагын тухай • Хувийн хамгаалалтын байгууллагын эрх, үүрэг • Хувийн хамгаалалтын байгууллагын удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны нийтлэг зохицуулалт • Үйлчлүүлэгчийн эрх, үүрэг хариуцлага • Хувийн хамгаалалтын үйл ажиллагааны нууцлал 	2	2	-	Хувийн хамгаалалтын үйл ажиллагаа болон алба хаагчийн эрх зүйн байдлыг зохицуулсан хууль тогтоомжийн талаар мэдлэг олгож, зөв хэрэглэх чадварыг эзэмшүүлнэ.
		<ul style="list-style-type: none"> • Хувийн хамгаалалтын байгууллагын алба хаагчийн нийтлэг эрх, үүрэг, хүлээх хариуцлага, үйл ажиллагаанд хориглох зүйл • Хувийн хамгаалалтын ажилтны сахилга, ёс зүйд тавигдах шаардлага, хүлээлгэх хууль зүйн хариуцлага • Хувийн хамгаалалтын алба хаагчийн хөдөлмөрлөх эрх, нийгмийн бусад баталгааг хангах / хөдөлмөрийн гэрээ байгуулах, ажил, амралтын цаг, илүү цагийн хөлс, нийгмийн даатгалд хамрагдах асуудлууд/ 	2	2	-	Хувийн хамгаалагчийн хууль зүй, нийгмийн баталгааны мэдлэг төлөвшинө.

Төсөл

2	Хувийн хамгаалалтын ажилтнаас албадлага хэрэглэх үндэслэл, журам	<ul style="list-style-type: none"> • Хүний эрх, эрх чөлөөг хууль тогтоомжоор хамгаалах шаардлага, ач холбогдол • Албадлагын ойлголт, гэрээт харуул хамгаалалтын алба хаагчаас хэрэглэх албадлагын төрөл • Галт зэвсгийн ойлголт, төрөл, эрх зүйн зохицуулалт • Биеийн хүч хэрэглэх • Нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх үндэслэл, журам 	12	4	8	Хүний эрх, эрх чөлөөг дээдэлж, зөвхөн хууль тогтоомжийн дагуу албадлага хэрэглэх мэдлэг, дадал, чадварыг эзэмшүүлнэ
3	Хувийн хамгаалалтын байгууллага, алба хаагч цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах	<ul style="list-style-type: none"> • Гэмт хэрэг, зөрчлийн тухай ойлголт, хүлээлгэх хариуцлага • Хувийн хамгаалалтын байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын чиглэлээр хүлээх үүрэг • Гэмт хэрэг, зөрчлийн талаар цагдаагийн байгууллагад мэдээлэх, харилцан мэдээлэл солилцох, гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоох, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, нийтийн хэв журам хамгаалах чиглэлээр цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах 	8	6	2	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хандлага төлөвшинэ.
4	Галын аюул учрахаас сэргийлэх, эрсдэлийн үед ажиллах журам	<ul style="list-style-type: none"> • Галын аюулгүй байдлын ойлголт • Гал унтраах техник хэрэгсэлд тавигдах стандарт, шаардлага • Галын аюулаас урьдчилан сэргийлэх, гал түймэр гарсан тухай мэдээлж онцгой байдлын байгууллагатай хамтран ажиллах • Гал унтраах анхан шатны техник ажиллагаа • Галд өртөмтгий бодис, техник хэрэгслийн хадгалалт, хамгаалалтад тавигдах шаардлага • Учирч болзошгүй бусад эрсдэл учирсан үед ажиллах арга, тактик 	6	2	4	Байгууллагад эрсдэл учрахаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийн үед ажиллах арга, тактикийн мэдлэг, ур чадвар эзэмшүүлнэ
5	Хувийн хамгаалалтын алба хаагчийн аюулгүй байдлыг хангах	<ul style="list-style-type: none"> • Алба хаагчийн аюулгүй байдлын тухай ойлголт • Алба хаагчийн аюулгүй байдлыг хангахад байгууллагын хүлээх үүрэг • Алба хаагч өөрийн аюулгүй байдлыг хангахад анхаарах асуудал • Хамгаалах тусгай хэрэгсэл хэрэглэх 	6	2	4	Аюулгүй байдлаа хангаж ажиллах мэдлэг, ур чадварыг эзэмшүүлнэ
6	Эмнэлгийн анхан шатны тусламж	<ul style="list-style-type: none"> • Гэмтэж, бэртсэн, шархадсан, оюун санааны хүчтэй нөлөөлөлд өртсөн хүнд эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх 	6	2	4	Эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх мэдлэг, ур чадварыг эзэмшүүлнэ

7	Харилцааны соёл, сэтгэл зүйн бэлтгэл	<ul style="list-style-type: none"> • Харилцааны ур чадварын тухай ойлголт • Олон нийттэй харилцах арга зүй • Нөхцөл байдлыг зөв үнэлж бусадтай харилцах ур чадвар • Гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдтэй харилцах, байгал, цаг агаарын болон онцгой нөхцөлд үүрэг гүйцэтгэх сэтгэл зүйн бэлтгэлийг хангахад анхаарах асуудал 	6	4	2	Бусадтай харилцах ур чадварын түвшинг дээшлүүлнэ
8	Бичиг баримт хөтлөх, боловсруулах арга зүй	<ul style="list-style-type: none"> • Илтгэл, тайлан, мэдээ бичих арга зүй • Албаны бичиг баримтыг хөтлөх, үйлдэх • Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үндсэн стандарт, ойлголтууд 	4	2	2	Бичиг баримт хөтлөх, боловсруулах чадавх дээшилнэ.
9	Хяналт, Холбоо, мэдээллийн хэрэгсэл	<ul style="list-style-type: none"> • Хувийн хамгаалалтын байгууллагын хяналт, холбоо, мэдээллийн хэрэгсэл, түүний зориулалт • Холбоо, мэдээллийн хэрэгслийг ашиглах арга зүй 	4	2	2	Шуурхай байдал нь хангагдана.
Нийт		9 хэсэг, 38 сэдэв	56	28	28	
Хоёр: Хувийн хамгаалалтыг биечлэн гүйцэтгэх алба хаагчийн давтан сургалт						
1	Хувийн хамгаалалтын мэргэжлийн болон давтан сургалтад шаардлагатай бусад сэдэв, чиглэл	<ul style="list-style-type: none"> • Үйлчлүүлэгчийн байрлах гэр, ажлын байр, байгууллагын орчны судалгаа • Тэсэрч дэлбэрэх бодис, төхөөрөмжийн тухай ойлголт • Химийн болон бусад хорт бодисын тухай ойлголт • Тээврийн хэрэгсэл шалгах • Орчиндоо хяналт явуулах, ажиглалт хийх • Үүссэн нөхцөл байдалд /Аюулын байдал/ үнэлэлт дүгнэлт хийх, шийдвэр гаргах • Үйлчлүүлэгч халдлагад өртөх үед алба хаагчийн ажиллагаа /Халдлагыг таслан зогсоох/ • Сэтгэл зүйн бэлтгэл /Тэсвэр, хатуужил суулгах/ 	14	4	10	Хувийн хамгаалалтын үйл ажиллагаа болон алба хаагчийн мэдлэг, ур чадвар дээшилнэ.
Нийт		1 хэсэг, 8 сэдэв	14	4	10	

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын хамтарсан 2018 оны дугаар сарын-ны өдрийн /..... дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ХУВИЙН ХАМГААЛАЛТЫН СУРГАЛТ ЯВУУЛАХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, ҮЙЛ АЖИЛЛАГААНД НЬ ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Хувийн хамгаалалтын сургалт явуулах хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдэд зөвшөөрөл олгох, бүртгэх, зөвшөөрлийг сунгах, хүчингүй болгох, сургалтын үйл ажиллагаанд нь хяналт тавихад энэ журмыг мөрдөнө.

1.2.Хувийн хамгаалалтын сургалт явуулах иргэн, хуулийн этгээд Хувийн хамгаалалтын тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн акт, энэхүү журмыг баримтална.

1.3.Дээд боловсролын тухай хууль тогтоомжид зааснаар хувийн хамгаалалтын чиглэлээр дээд боловсролын диплом, бакалаврын зэрэгтэй иргэн энэхүү журмын үндсэн мэргэшлийн сургалтад хамрагдахгүй.

Хоёр.Хувийн хамгаалалтын сургалтын хэлбэр, агуулгын багтаамж, хугацаа

2.1.Хувийн хамгаалалтын үндсэн мэргэшлийн сургалтад хувийн хамгаалалт эрхлэх этгээдийн захиалгаар, эсхүл иргэн хүсэлтээр суралцана.

2.2.Хувийн хамгаалалтын сургалтыг үндсэн мэргэшлийн, давтан сургалт гэсэн хэлбэрээр зохион байгуулна.

2.3.Хувийн хамгаалалтын сургалтын багтаамжийг багц цагаар хэмжинэ.

2.4.Хувийн хамгаалалтын үндсэн мэргэшлийн сургалт нь 56 багц цагаас доошгүй агуулгатай, ажлын 7 хоногоос доошгүй хугацаанд үргэлжилнэ.

2.5.Хувийн хамгаалалтын давтан сургалт нь мэргэжлийн чиглэлээр нэмэлт мэдлэг, ур чадварыг олгоход чиглэгдэнэ.

2.6.Давтан сургалтын багц цаг нь 1 жил тутам 14 багц цагаас доошгүй агуулгатай байх бөгөөд хувийн хамгаалалтын чиглэлээр ажиллаж байгаа нөхцөлд заавал энэхүү багц цагийг хангасан байхыг шаардана.

2.7.Хувийн хамгаалалтын үндсэн мэргэшлийн сургалтыг жил бүрийн 03 дугаар сарын 01, 10 дугаар сарын 01-нээс, давтан сургалт нь жилийн туршид зохион байгуулагдана.

2.8.Хувийн хамгаалалтын үндсэн мэргэшлийн сургалтын гэрчлэх баримт бичиг нь мэргэшлийн үнэмлэх байна.

2.9.Давтан сургалтын багц цагийн сургалт нь бие хамгаалагчдын энэ журмын 2.6-д заасан багц цагийг хангахад чиглэгдсэн сэдэвчилсэн, танхимын

сургалт байх бөгөөд гэрчлэх баримт бичиг нь багц цагийн тэмдэглэгээ бүхий гэрчилгээ байна.

2.10.Үндсэн мэргэшлийн сургалт дууссанаас хойш төгсөлтийн шалгалтыг ажлын 5 хоногт зохион байгуулж, хамгаалалтын үйл ажиллагаа явуулах иргэн, хуулийн этгээд, цагдаагийн байгууллагаас төлөөллийг шалгалт авах бүрэлдэхүүнд оролцуулж болно.

2.11.Хувийн хамгаалалтын сургалт явуулах зөвшөөрөл бүхий иргэн, хуулийн этгээд нь үндсэн мэргэшлийн сургалт төгсөгчдийн нэрсийн жагсаалт, мэргэшлийн үнэмлэхийн нэгдсэн бүртгэлийн дугаарыг нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад бүртгүүлнэ.

2.12.Давтан сургалтад хамрагдах бие хамгаалагчийн талаар хуулийн этгээд захиалга өгөх, иргэн хүсэлт гаргах тохиолдолд суралцагчид хувийн хамгаалалтын үндсэн мэргэшүүлэх сургалтын гэрчилгээтэй байхыг шаардана.

2.13.Давтан сургалтын гэрчилгээг сургалт явуулсан иргэн, хуулийн этгээд баталгаажуулна.

Гурав.Хувийн хамгаалалтын сургалтыг бүртгэх, зөвшөөрөл олгох

3.1.Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 14.3 дахь хэсэг, мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичигт тавих шаардлага, загвар¹”-ын дагуу иргэн, хуулийн этгээд нь хувийн хамгаалалтын сургалт явуулах зөвшөөрөл авах баримт бичиг бүрдүүлнэ.

3.2.Иргэн, хуулийн этгээдийн хувийн хамгаалалтын сургалтыг боловсролын болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдийн хамтран баталсан “Мэргэжлийн сургалтын байгууллагыг бүртгэх, сургалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тогтоох журам²”-д зааснаар бүртгэж, зөвшөөрөл олгоно.

Дөрөв.Хувийн хамгаалалтын сургалтын үйл ажиллагаанд тавих хяналт

4.1.Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага нь хувийн хамгаалалтын сургалтын үйл ажиллагаанд дараах чиглэлээр хяналт тавина.

4.1.1.хувийн хамгаалалтын сургалт явуулах иргэн, хуулийн этгээдийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, зөвлөгөө өгөх;

4.1.3.хувийн хамгаалалтын сургалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээд болон төгсөгчдийн талаар тоо бүртгэл хөтлөх;

4.1.4.хувийн хамгаалалтын сургалтын агуулга, төлөвлөгөөнд санал өгөх;

4.1.5.хувийн хамгаалалтын сургалтын үйл ажиллагаанд явцын хяналт, шалгалт, үнэлгээ хийх, үр дүнг эрх бүхий албан тушаалтанд тайлагнах, тодорхойлолт өгөх;

4.1.6.хувийн хамгаалалтын үндсэн мэргэшлийн сургалтын гэрчилгээ олгох шалгалтад оролцож, санал гаргах.

¹Хөдөлмөрийн сайдын 2016 оны А/53 дугаар тушаал.

²Хөдөлмөр, нийгмийн хамгааллын болон Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2016 оны А/216, А/104 дүгээр тушаал.

Тав.Бусад

5.1.Хувийн хамгаалалтын сургалт явуулж байгаа иргэн, хуулийн этгээд үйл ажиллагааны тайланг жил бүрийн 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад хүргүүлнэ.

---o0o---